



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/370

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.2, 10.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан 2017 оны 06 дугаар сарын 14-нөөс 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд бэлтгэлд гарч буй Орхон аймгийн харъяат бөхчүүдэд 1550000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 1550000 /Нэг сая таван зуун тавин мянган / төгрөгийг Засаг даргын нөөцийн сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ